



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: СБА-2022/20/НА-СТА-ТШЗ

| | |
|---|--|
| <p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Баруун-Урт 2022 он</p> | <p>Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Нарантуяа Утас: 70518396 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Утас: 70512123 Цахим хаяг: davaag@audit.gov.mn</p> <p>Аудитор: Утас: 70512127 Цахим хаяг: altansukhe@audit.gov.mn</p> |
|---|--|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

| | |
|--|----|
| 1. Аудитын санал дүгнэлт | 2 |
| 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл | 4 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан | 4 |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан | 5 |
| 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан | 6 |
| 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан | 7 |
| 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан | 8 |
| 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан | 10 |
| 3. Аудитын тайлан | 10 |
| 3.1 Ерөнхий зүйл | 10 |
| 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт | 11 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал | 11 |
| 3.4 Материаллаг байдал | 11 |
| 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга | 11 |
| 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв | 12 |
| 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг | 13 |
| 3.8 Аудитын гол асуудал | 14 |
| 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 14 |
| 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт | 14 |
| 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 15 |
| 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал | 15 |
| 4. Аудитын илрүүлэлт | 15 |
| 4.1 Зөвлөмж | 15 |
| 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл | 16 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ИТХ | Иргэдийн Төлөөлөгчдийн хурал |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |

1. Аудитын санал дүгнэлт



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

Хөдөл. 02.24 № 19

танай _____-ны № _____-т

СҮХБААТАР АЙМГИЙН ХӨДӨЛМӨР,
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГА Д.ГЭРЭЛБАДРАХ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *М.Нарантуяа* М.НАРАНТУЯА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------|--|------------------------------|------------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | <u>32,381,543.00</u> | <u>20,765,925.00</u> |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 32,381,543.00 | 20,765,925.00 |
| 351 | Түүхий эд материал | 221,600.00 | 95,000.00 |
| 35130 | Эм боох материал | 221,600.00 | 95,000.00 |
| 354 | Хангамжийн материал | 32,159,943.00 | 20,670,925.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,536,650.00 | 1,196,752.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 20,721,734.00 | 15,842,551.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 739,500.00 | 669,500.00 |
| 35460 | Хүнсний материал | 2,323,040.00 | 00.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 6,839,019.00 | 2,962,122.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | <u>668,879,528.05</u> | <u>534,147,712.26</u> |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 668,879,528.05 | 534,147,712.26 |
| 392 | Биет хөрөнгө | 548,924,528.01 | 508,022,712.26 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 512,477,199.94 | 445,721,546.08 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -40,040,684.74 | -34,856,288.18 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 221,800,000.00 | 184,800,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -216,899,999.96 | -181,533,333.28 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 242,747,222.06 | 199,083,954.61 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -204,931,620.34 | -148,557,117.83 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 131,462,695.70 | 86,104,593.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -97,970,454.71 | -42,904,312.24 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 2,648,330.00 | 1,165,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -2,368,159.94 | -1,001,329.90 |
| 393 | Биет бус хөрөнгө | 119,955,000.04 | 26,125,000.00 |
| 39301 | Програм хангамж | 16,476,900.00 | 16,476,900.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -3,251,899.96 | -7,081,900.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 106,730,000.00 | 16,730,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | <u>701,261,071.05</u> | <u>554,913,637.26</u> |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | <u>701,261,071.05</u> | <u>554,913,637.26</u> |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 701,261,071.05 | 554,913,637.26 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 393,006,254.41 | 393,006,254.41 |
| 51101 | Өмч: - төрийн | 393,006,254.41 | 393,006,254.41 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 306,173,702.56 | 159,826,268.77 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 306,173,702.56 | 306,173,702.56 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -146,347,433.79 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,081,114.08 | 2,081,114.08 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | <u>701,261,071.05</u> | <u>554,913,637.26</u> |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 811,689,550.00 | 849,454,948.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 155,137,650.00 | 211,688,548.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 155,137,650.00 | 211,688,548.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 155,137,650.00 | 211,688,548.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 124,096,500.00 | 17,248,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 31,041,150.00 | 194,440,548.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 656,551,900.00 | 637,766,400.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 639,414,900.00 | 629,316,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 639,414,900.00 | 629,316,400.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 17,137,000.00 | 8,450,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 14,137,000.00 | 8,450,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 3,000,000.00 | 00.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 826,722,284.06 | 710,660,334.86 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 826,722,284.06 | 710,660,334.86 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 792,551,478.25 | 682,832,260.99 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 475,405,874.35 | 478,523,106.67 |
| 210101 | Үндсэн цалин | 371,225,995.44 | 376,222,277.27 |
| 210102 | Нэмэгдэл | 85,959,778.91 | 78,796,591.24 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 18,220,100.00 | 23,354,238.16 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 150,000.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 59,023,267.30 | 61,137,469.41 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 41,091,049.04 | 43,264,827.38 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,834,241.13 | 4,807,911.22 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,252,297.23 | 3,816,088.51 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,380,238.62 | 840,786.08 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,465,441.28 | 8,407,856.22 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 53,328,745.68 | 41,287,099.60 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 28,390,385.68 | 19,147,658.50 |
| 210302 | Түлш, халаалт | 19,183,480.00 | 18,960,480.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,754,880.00 | 3,178,961.10 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 24,506,990.03 | 21,081,276.48 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,813,644.00 | 5,180,743.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,180,220.00 | 3,770,850.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,337,784.03 | 1,864,287.48 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 605,500.00 | 180,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,569,842.00 | 6,348,494.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 00.00 | 3,736,902.00 |
| 2105 | Нормативт зардал | 39,523,021.00 | 8,758,437.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 504,169.50 | 92,400.00 |
| 210502 | Хоол, хүнс | 37,678,171.50 | 8,622,537.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,340,680.00 | 43,500.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,032,899.00 | 1,477,600.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 5,032,899.00 | 1,477,600.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 3,378,000.00 | 1,956,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,378,000.00 | 1,956,500.00 |

Сүхбаатар аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | |
|-------------|--|-----------------------|------------------------|
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 75,491,407.83 | 15,817,368.97 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 71,239,829.83 | 12,896,130.97 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,180,000.00 | 00.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,270,000.00 | 1,270,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 270,000.00 | 209,588.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 80,076.00 | 143,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 346,000.00 | 1,214,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 105,502.00 | 83,650.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 56,861,273.06 | 52,793,402.86 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 10,369,969.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 56,861,273.06 | 42,423,433.86 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 34,170,805.81 | 27,828,073.87 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 5,033,699.00 | 830,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,033,699.00 | 830,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 29,137,106.81 | 26,998,073.87 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 29,137,106.81 | 26,998,073.87 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | -15,032,734.06 | 138,794,613.14 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 00.00 | 285,142,046.93 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 00.00 | 285,142,046.93 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | 00.00 | -285,142,046.93 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | -15,032,734.06 | -146,347,433.79 |

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|--|---------------------------------|-----------------------|-----------------------|--------------|---|
| 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 393,006,254.41 | 2,081,114.08 | 306,173,702.56 | 00.00 | 701,261,071.05 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 393,006,254.41 | 2,081,114.08 | 306,173,702.56 | 00.00 | 701,261,071.05 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -146,347,433.79 | 00.00 | -146,347,433.79 |
| 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 393,006,254.41 | 2,081,114.08 | 159,826,268.77 | 00.00 | 554,913,637.26 |

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 780,948,400.00 | 655,014,400.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 124,096,500.00 | 17,248,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 124,096,500.00 | 17,248,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 124,096,500.00 | 17,248,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 124,096,500.00 | 17,248,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 656,851,900.00 | 637,766,400.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 639,414,900.00 | 629,316,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 639,414,900.00 | 629,316,400.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 17,437,000.00 | 8,450,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 14,437,000.00 | 8,450,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 3,000,000.00 | 00.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 774,381,221.00 | 652,618,410.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 774,381,221.00 | 652,618,410.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 740,210,415.19 | 624,790,336.13 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 475,405,874.35 | 478,523,106.67 |
| 210101 | Үндсэн цалин | 371,225,995.44 | 376,222,277.27 |
| 210102 | Нэмэгдэл | 85,959,778.91 | 78,796,591.24 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 18,220,100.00 | 23,354,238.16 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 150,000.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 59,023,267.30 | 61,137,469.41 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 41,091,049.04 | 43,264,827.38 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,834,241.13 | 4,807,911.22 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,252,297.23 | 3,816,088.51 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,380,238.62 | 840,786.08 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,465,441.28 | 8,407,856.22 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 53,328,745.68 | 41,287,099.60 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 28,390,385.68 | 19,147,658.50 |
| 210302 | Түлш, халаалт | 19,183,480.00 | 18,960,480.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,754,880.00 | 3,178,961.10 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 25,775,500.03 | 16,982,296.48 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,158,244.00 | 4,876,845.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,180,220.00 | 3,770,850.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,337,784.03 | 1,864,287.48 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 605,500.00 | 180,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8,493,752.00 | 6,290,314.00 |
| 2105 | Нормативт зардал | 42,005,171.00 | 6,520,397.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 504,169.50 | 177,400.00 |
| 210502 | Хоол, хүнс | 40,001,221.50 | 6,299,497.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,499,780.00 | 43,500.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,502,449.00 | 2,566,098.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 5,502,449.00 | 2,566,098.00 |
| 2107 | Томиллолт, зочны зардал | 3,378,000.00 | 1,956,500.00 |
| 210702 | Дотоод албан томиллолт | 3,378,000.00 | 1,956,500.00 |

Сүхбаатар аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | |
|-------------|--|-----------------------------|-----------------------------|
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 75,791,407.83 | 15,817,368.97 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 71,539,829.83 | 12,896,130.97 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,180,000.00 | 00.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,270,000.00 | 1,270,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 270,000.00 | 209,588.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 80,076.00 | 143,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 346,000.00 | 1,214,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 105,502.00 | 83,650.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 34,170,805.81 | 27,828,073.87 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 5,033,699.00 | 830,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,033,699.00 | 830,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 29,137,106.81 | 26,998,073.87 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 29,137,106.81 | 26,998,073.87 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | <u>6,567,179.00</u> | <u>2,395,990.00</u> |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | <u>6,567,179.00</u> | <u>2,395,990.00</u> |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | <u>6,567,179.00</u> | <u>2,395,990.00</u> |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 6,567,179.00 | 2,395,990.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 6,567,179.00 | 2,395,990.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | <u>-6,567,179.00</u> | <u>-2,395,990.00</u> |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 00.00 | 00.00 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 | 00.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 | 00.00 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|-----------------------|---|-----------------------|-----------------------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 750,861,800.00 | 620,889,763.48 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 750,861,800.00 | 620,889,763.48 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 750,029,200.00 | 620,059,763.48 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 478,607,700.00 | 478,373,106.67 |
| 210101 | Үндсэн цалин | 357,341,600.00 | 376,222,277.27 |
| 210102 | Нэмэгдэл | 106,375,500.00 | 78,796,591.24 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 14,890,600.00 | 23,354,238.16 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 64,612,100.00 | 61,137,469.41 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 45,467,700.00 | 43,264,827.38 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,786,100.00 | 4,807,911.22 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,828,900.00 | 3,816,088.51 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 957,200.00 | 840,786.08 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,572,200.00 | 8,407,856.22 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 61,555,600.00 | 41,287,099.60 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 35,656,000.00 | 19,147,658.50 |
| 210302 | Түлш, халаалт | 20,041,000.00 | 18,960,480.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,858,600.00 | 3,178,961.10 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 18,565,200.00 | 12,686,233.83 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,998,100.00 | 2,527,440.00 |

**Сүхбаатар аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

| | | | |
|---------------|--|-----------------------|-----------------------|
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,142,700.00 | 2,551,850.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,428,800.00 | 1,236,929.83 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 637,100.00 | 180,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 11,358,500.00 | 6,190,014.00 |
| 2105 | Нормативт зардал | 38,140,000.00 | 6,520,397.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,000,000.00 | 177,400.00 |
| 210502 | Хоол, хүнс | 35,640,000.00 | 6,299,497.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,500,000.00 | 43,500.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 4,962,400.00 | 4,962,088.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,962,400.00 | 4,962,088.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 280,800.00 | 276,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 280,800.00 | 276,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 83,305,400.00 | 14,817,368.97 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 80,855,400.00 | 12,896,130.97 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,270,000.00 | 1,270,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 270,000.00 | 209,588.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 150,000.00 | 143,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 400,000.00 | 214,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 360,000.00 | 83,650.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 832600.00 | 830000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 832,600.00 | 830,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 832,600.00 | 830,000.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 750,861,800.00 | 620,889,763.48 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 629,316,400.00 | 603,641,763.48 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 629,316,400.00 | 603,641,763.48 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 121,545,400.00 | 17,248,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 121,545,400.00 | 17,248,000.00 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 | 00.00 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 | 00.00 |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|-------------|--|---------------------|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 7,126,562.65 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 7,126,562.65 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 7,126,562.65 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 150,000.00 |
| 210104 | Урамшуулал | 150,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 4,296,062.65 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,349,405.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,219,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 627,357.65 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 100,300.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,680,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,680,500.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,000,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,000,000.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 7126562.65 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 7,126,562.65 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 7,126,562.65 |
| IV | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I) | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | |

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд үндсэн хөрөнгө, түлш халаалтын зардалтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Э.Алтансүх гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1/57 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сүхбаатар аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь “Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдэл ядуурлыг бууруулах, нийгмийн халамжийн үйлчилгээг чанартай, үр дүнтэй, шуурхай хүргэх замаар нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын зорилго оршино.” гэсэн эрхэм зорилготой байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 826,722.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 12,400.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 9,300.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сүхбаатар аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 146,347.4 мянган

төгрөгөөр буюу 20.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|------------------|------------------|--------------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Бараа материал | 32,381.5 | 20,765.9 | - 11,615.6 |
| Үндсэн хөрөнгө | 668,879.5 | 534,147.7 | - 134,731.8 |
| Нийт хөрөнгө | 701,261.1 | 554,913.6 | - 146,347.4 |
| Засгийн газрын оруулсан капитал | 393,006.3 | 393,006.3 | - |
| Хуримтлагдсан үр дүн | 306,173.7 | 159,826.3 | - 146,347.4 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,081.1 | 2,081.1 | |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 701,261.1 | 554,913.6 | - 146,347.4 |

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 534,147.7 мянган төгрөг болж 134,731.8 мянган төгрөгөөр буурсан байна. Үндсэн хөрөнгийн данс буурахад аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 31 дүгээр тогтоолоор “Амгалант дэнж улсын төсөвт үйлдвэрийн газар”-т 280,064.8 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй үндсэн хөрөнгийг шилжүүлсэн нь голлон нөлөөлжээ. Мөн тайлант онд бусад эх үүсвэрээс үнэ төлбөргүй 190,437.7 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Сүхбаатар аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 37,765.4 мянган төгрөгөөр буюу 4.7 хувиар нэмэгдсэн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан туслах үйл ажиллагааны орлого, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогын данс байна. Тодруулбал тайланд онд ахмадын сувиллын үйл ажиллагааг шилжүүлсэнтэй холбоотойгоор туслах үйл ажиллагааны орлого 106,848.5 мянган төгрөгөөр буурсан байна. Харин үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 163,399.4 мянган төгрөгөөр буюу 526.4 хувиар өсөж, тайлант үед 194,440.5 мянган төгрөг болсон байна. Энэ нь 4,002.8 мянган төгрөгийн материал, 190,437.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, нийт 194,440.5 мянган төгрөгийн хөрөнгө, материал үнэ төлбөргүй хүлээн авснаас шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 169,080.1 мянган төгрөгөөр буюу 20.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан гэрэл, цахилгааны зардал, хоол, хүнсний зардал, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж, үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз зэрэг зардлууд байна. Энэ нь 477,094.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 191,952.0 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй хөрөнгийг данснаас хассаны 285,142.0 мянган төгрөгийн гарзтай холбоотойгоор зардал нэмэгдэж, сувиллын үйл ажиллагааг 2021 оны 5 сард “Амгалант дэнж улсын төсөвт үйлдвэрийн газар”-т шилжүүлсэнтэй холбоотойгоор гэрэл цахилгааны зардал 9,242.7 мянган төгрөг, хоол, хүнсний зардал 29,055.6 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 58,343.7 мянган төгрөгөөр тус тус буурснаас шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 912,626.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 912,626.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 150,897.2 мянган төгрөгөөр бууруулж 761,728.9 мянган төгрөгөөр баталсан байна. Харин төсвийн тодотголоор тус байгууллагын төсөв 10,867.1 мянган төгрөгөөр хасагджээ. Төсвийн төслөөс тайлант оны төсөв нь 150,897.2 мянган төгрөгөөр бага дүнгээр батлагдаж, төсөв 10,867.1 мянган төгрөгөөр хасагдсан боловч тухайн байгууллагын 2021 онд хэрэгжүүлэх 22 ажил үйлчилгээ бүхий “Гүйцэтгэлийн төлөвлөгөө” 92.4 хувьтай хэрэгжсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 761,728.9 мянган төгрөгийн төсөв баталснаас 640,183.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 121,545.4 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 629,316.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны 17,248.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 620,889.8 мянган төгрөгийг зарцуулж, 25,674.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 620,889.8 мянган төгрөг буюу 82.7 хувьтай байгаа нь сувиллын үйл ажиллагааг 2021 оны 5 сард “Амгалант дэнж улсын төсөвт үйлдвэрийн газар”-т шилжүүлсэнтэй холбоотойгоор гэрэл цахилгааны зардал 16,508.3 мянган төгрөг, хоол, хүнсний зардал 29,340.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 67,959.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэнтэй холбоотой байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсөв захирагчаас 8,450.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт авч, 7,126.6 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулж, 1,323.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Сүхбаатар аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын үйл ажиллагаа нь 16 нэр төрлийн үйл ажиллагаанаас бүрддэг байна. Тодруулбал Нийгмийн халамжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтад нийгмийн халамжийн 4 үйл ажиллагаа, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь заалтад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 12 үйл ажиллагааг зааж өгсөн байна.

Сүхбаатар аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 27 дугаар тогтоолоор ахмадын сувиллын чиглэлээр үйл ажиллагаа явуулах “Амгалант дэнж улсын төсөвт үйлдвэрийн газар” байгуулагдаж, Сүхбаатар аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын данс

бүртгэлээс 280,064.8 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй үндсэн хөрөнгө, 10,370.0 мянган төгрөгийн өртөгтэй бараа материалыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 31 дүгээр тогтоолоор тус үйлдвэрийн газарт шилжүүлсэн байна.

Тайлант онд төслийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 хөтөлбөр, 3 арга хэмжээний хэрэгжилт 92.4 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 82.7 хувийн биелэлттэй байна.

3.8 Аудитын гол асуудал

Сүхбаатар аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын үйл ажиллагаа, тайлант хугацаанд гарсан ажил гүйлгээ, үйл явдал болон засаглах эрх бүхий этгээдүүдийн түвшин дэх харилцаатай холбоотой санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 149 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолоор төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн 9 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг бүх шатны байгууллагын төсөв захирагч нарт даалгасан байна. Тухайлбал:

- Тогтоолын 1.1-д “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”
- Тогтоолын 1.8-д “байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах; гэж заасан байна”

Сангийн яамнаас 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн “Тодруулга хүргүүлэх тухай” Н-3/845 дугаар албан бичгийг Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна. Тус албан бичигт “Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д заасан “үндсэн үйл ажиллагаатай холбоотой зайлшгүй шаардлагатай зардал, төсөл, арга хэмжээ” гэдэгт төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор ажилтан, албан хаагчдад төлж байгаа цалин хөлс, олговор, ажил олгогчоос төлөх нийгмийн болон эрүүл мэндийн

даатгалын шимтгэл, цахилгаан, халаалт, цэвэр, бохир ус, түрээсийн зардал болон байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой шаардлагатай бусад зардал хамаарна.” гэж тодруулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Сүхбаатар аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт "Итгэл" үзүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сүхбаатар аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын тайлант оны үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэл, ажил гүйлгээ болон санхүүгийн тайланг тасалбар болгож гаргасан өдрөөс хойших үйл явдлыг шинжилж үзэхэд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар үндсэн хөрөнгө болон түлш халаалтын зардалтай холбоотой нийт 2 зөрчил илэрсэнд зөвлөмж өгсөн.

4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 146 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчил нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан “Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана” заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн эдийн засгийн нас буюу ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлийг мөрдөж ажиллах.

2. Түлш халаалтын зардалтай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Байгууллагын барилгад дулааны тоолуур суурилуулаагүй нь Засгийн газрын 2020 оны 144 дүгээр тогтоолын 1 дэх “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөвт байгууллагын дулааны эрчим хүчний хэрэглээг хэмжүүрээр тооцох нөхцөлийг бүрдүүлж, тоолуур суурилуулах ажлыг 2020 оны 3-р улиралд багтаан зохион байгуулж,

хэрэгжүүлэхийг төсвийн захирагч, гүйцэтгэх удирдлага нарт үүрэг болгосугай” заалттай нийцэхгүй байна.

2.1. Өгсөн зөвлөмж:

Байгууллагын барилгад дулааны тоолуур суурилуулж, дулааны эрчим хүчний төлбөрийг Эрчим хүчний зохицуулах хорооны 2021 оны 10 сарын 14-ний өдрийн 461 дүгээр тогтоолоор батлагдсан “Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф”-ыг мөрдөж, Засгийн газрын 2020 оны 144 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|-----|--|----------------------|-----|-----------|-----|-----------|-----|-------|-----|---------|-----|
| | | | | Залруулга | | Төлбөрийн | | Албан | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Сүхбаатар аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар | 2 | - | - | - | - | - | - | - | 2 | - |